



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Б.Бүрэнжаргал
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/140
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Х.ЭНХСҮРЭН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. Үүнд:

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дугаар сарын 02-ны Б/02 тушаалаар Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны эхний хагас жилд 22,888.0 мянган төгрөгийн цалинг албан хаагчдад илүү олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д "Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр

6724040296

зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах,” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс 7,601.7 мянган төгрөгөөр давсан.

Асуудлыг онцолсон хэсэг

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 36.9 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг бодогдсон цалингаас 514.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын дарга нь 2023 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө Сумын Засаг даргаар 4 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж 89.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>299,580,161.67</u>	<u>234,670,719.17</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	131,167,102.50	38,354,607.77
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	131,167,102.50	38,354,607.77
3121	Төгрөг	131,167,102.50	38,354,607.77
31211	Төрийн сангийн харилцах	131,167,102.50	38,354,607.77
33	АВЛАГА	-	18,255,692.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	18,255,692.00
35	БАРАА МАТЕРИАЛ	168,413,059.17	178,060,419.40
351	Түүхий эд материал	51,892,330.91	63,367,609.27
35130	Эм боох материал	51,892,330.91	63,367,609.27
354	Хангамжийн материал	113,670,728.26	114,692,810.13
35410	Бичиг хэргийн материал	5,640,100.00	5,029,240.00
35420	Аж ахуйн материал	22,017,778.47	18,734,840.31
35450	Барилгын засварын материал	-	280,500.00
35460	Хүнсний материал	6,564,456.00	6,703,018.00
35470	Бусад хангамжийн материал	79,448,393.79	83,945,211.82
35600	Мал амьтад	2,850,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>618,496,143.37</u>	<u>530,877,158.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	618,496,143.37	530,877,158.27
392	Биет хөрөнгө	598,881,393.34	511,493,408.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	339,314,680.90	355,454,680.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(62,154,960.56)	(81,086,459.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	152,889,792.00	61,276,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,577,779.94)	(35,817,194.26)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	227,640,185.29	273,539,409.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,703,060.97)	(105,625,303.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,375,857.36	72,905,857.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,903,320.74)	(29,153,583.05)
393	Биет бус хөрөнгө	19,614,750.03	19,383,750.03
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(140,249.97)	(371,249.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,600,000.00	18,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>918,076,305.04</u>	<u>765,547,877.44</u>
413	Өглөг	-	1,719,954.00
4136	Бусад өглөг	-	1,719,954.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,719,954.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>918,076,305.04</u>	<u>763,827,923.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	918,076,305.04	763,827,923.44

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	889,082,412.08	889,082,412.08
51101	Өмч: - төрийн	889,082,412.08	889,082,412.08
512	Хуримтлагдсан үр дүн	(206,982,641.82)	(361,231,023.42)
51210	Өмнөх үеийн үр дүн	(206,982,641.82)	(206,982,641.82)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(154,248,381.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	235,976,534.78	235,976,534.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>918,076,305.04</u>	<u>765,547,877.44</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,174,791,704.57	1,030,159,374.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	220,600,384.57	102,353,554.53
120	Нийтлэг татварын бус орлого	220,600,384.57	102,353,554.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,019,000.00	-
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	1,019,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	954,191,320.00	927,805,820.03
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	579,500.00	85,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	579,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	50,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,646,600.00	75,216,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,646,600.00	75,216,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	885,965,220.00	852,504,720.03
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	885,965,220.00	852,504,720.03
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	955,394,768.98	1,114,007,756.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	955,394,768.98	1,114,007,756.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	949,411,813.98	1,104,047,596.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,464,770.50	702,723,321.00
210101	Үндсэн цалин	366,838,365.33	439,553,662.01
210102	Нэмэгдэл	114,681,139.00	191,618,909.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,461,000.00	7,418,500.00
210104	Урамшуулал	24,484,266.17	64,132,249.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,143,780.00	87,515,562.76
210201	Тэтгэврийн даатгал	39,114,648.00	57,985,162.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,105,205.00	7,382,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,074,008.00	5,906,000.00

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	986,295.00	1,477,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,863,624.00	14,765,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,116,030.00	61,498,640.09
210301	Гэрэл, цахилгаан	2,979,061.00	4,453,860.13
210302	Түлш, халаалт	49,718,769.00	50,092,197.96
210303	Цэвэр, бохир ус	8,418,200.00	6,952,582.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,963,267.20	44,560,456.16
210401	Бичиг хэрэг	2,138,200.00	4,649,885.00
210402	Тээвэр, шатахуун	42,884,210.00	27,317,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,178,666.00	3,190,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,483,300.00	703,640.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,278,891.20	5,849,631.16
210408	Бараа материал акталсны зардал	-	2,850,000.00
2105	Нормативт зардал	140,465,915.76	79,262,008.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	133,618,778.76	71,866,825.64
210502	Хоол, хүнс	6,847,137.00	7,395,183.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,022,611.00	14,307,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,941,211.00	1,105,000.00
210604	Урсгал засвар	27,081,400.00	13,202,500.00
2107	Томилолт, зочны зардал	702,000.00	661,000.00
210702	Дотоод албан томилолт	702,000.00	661,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,170,987.00	2,261,672.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	566,400.00	1,140,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	890,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	330,300.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,500.00	205,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,375.00	-
210807	Газрын төлбөр	319,112.00	5,712.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990,300.00	829,285.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,362,452.52	111,257,435.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,369,401.00	7,629,026.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,993,051.52	103,628,409.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,982,955.00	9,960,159.91
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,982,955.00	9,960,159.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,982,955.00	9,960,159.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>219,396,935.59</u>	<u>(83,848,381.64)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	70,399,999.96
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	70,399,999.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(70,399,999.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>219,396,935.59</u>	<u>(154,248,381.60)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,003,133,420.00</u>	<u>909,550,128.03</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,923,100.00	-
122	Тусламжийн орлого	47,923,100.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	47,923,100.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	955,210,320.00	909,550,128.03
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,598,500.00	85,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	579,500.00	50,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,646,600.00	75,216,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,646,600.00	75,216,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	885,965,220.00	834,249,028.03
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	885,965,220.00	834,249,028.03
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>845,178,317.50</u>	<u>989,403,722.76</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	845,178,317.50	989,403,722.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,195,362.50	979,443,562.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,024,770.35	697,957,383.76
210101	Үндсэн цалин	366,479,493.00	434,787,724.77
210102	Нэмэгдэл	114,684,139.00	191,618,909.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,461,000.00	7,418,500.00
210104	Урамшуулал	24,400,138.35	64,132,249.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,143,780.15	92,281,500.00
210201	Тэтгэврийн даатгал	39,486,149.23	62,751,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,223,375.23	7,382,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,372,020.31	5,906,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	823,803.97	1,477,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,238,431.41	14,765,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,116,030.00	61,498,640.09
210301	Гэрэл, цахилгаан	2,979,061.00	4,137,189.12
210302	Түлш, халаалт	49,717,769.00	50,408,868.97
210303	Цэвэр, бохир ус	8,419,200.00	6,952,582.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,968,376.00	36,186,919.00
210401	Бичиг хэрэг	3,456,700.00	3,779,350.00
210402	Тээвэр, шатахуун	42,884,210.00	26,387,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,625,666.00	3,190,000.00
210404	Ном, хэвлэл	30,000.00	-

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,190,500.00	1,164,869.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,781,300.00	1,665,000.00
2105	Нормативт зардал	90,072,666.00	57,399,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,873,542.00	45,307,300.00
210502	Хоол, хүнс	8,174,124.00	9,100,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,025,000.00	2,992,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,217,200.00	22,718,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,103,300.00	9,095,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,492,500.00	209,200.00
210604	Урсгал засвар	26,621,400.00	13,414,500.00
2107	Томилолт, зочны зардал	702,000.00	661,000.00
210702	Дотоод албан томилолт	702,000.00	661,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,600,327.00	2,536,037.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	566,400.00	1,220,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	890,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	330,300.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,500.00	205,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,375.00	-
210807	Газрын төлбөр	319,112.00	5,712.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,419,640.00	1,023,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,350,213.00	8,203,483.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,350,213.00	8,203,483.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,982,955.00	9,960,159.91
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,982,955.00	9,960,159.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,982,955.00	9,960,159.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>157,955,102.50</u>	<u>(79,853,594.73)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,788,000.00	12,958,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,788,000.00	12,958,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,788,000.00	12,958,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,788,000.00	12,958,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(26,788,000.00)</u>	<u>(12,958,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	131,167,102.50	(92,812,494.73)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	131,167,102.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,167,102.50	38,354,607.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	889,082,412.08	235,976,534.78	(426,379,577.41)	698,679,369.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	889,082,412.08	235,976,534.78	(426,379,577.41)	698,679,369.45
Тайлант үеийн үр дүн	-	-	219,396,935.59	219,396,935.59
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	889,082,412.08	235,976,534.78	(206,982,641.82)	918,076,305.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	889,082,412.08	235,976,534.78	(206,982,641.82)	918,076,305.04
Тайлант үеийн үр дүн	-	-	(154,248,381.60)	(154,248,381.60)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	889,082,412.08	235,976,534.78	(361,231,023.42)	763,827,923.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,056,793,900.00	1,002,362,622.76	54,431,277.24	94.8
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,056,793,900.00	1,002,362,622.76	54,431,277.24	94.8
210	Бараа, үйлчилгээний зардал	1,056,793,900.00	992,402,462.85	64,391,437.15	93.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,923,200.00	697,957,383.76	30,965,816.24	95.8
210101	Үндсэн цалин	469,796,600.00	434,787,724.77	35,008,875.23	92.5
210102	Нэмэгдэл	193,347,100.00	191,618,909.11	1,728,190.89	99.1
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	2,160,000.00	7,418,500.00	(5,258,500.00)	343.4
210104	Урамшуулал	63,619,500.00	64,132,249.88	(512,749.88)	100.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,281,500.00	92,281,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	62,751,100.00	62,751,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,382,000.00	7,382,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	5,906,000.00	5,906,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,477,200.00	1,477,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,765,200.00	14,765,200.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,216,100.00	61,498,640.09	8,717,459.91	87.6
210301	Гэрэл цахилгаан	4,125,000.00	4,137,189.12	(12,189.12)	100.3
210302	Түлш, халаалт	60,643,400.00	50,408,868.97	10,234,531.03	83.1
210303	Цэвэр, бохир ус	5,447,700.00	6,952,582.00	(1,504,882.00)	127.6

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	36,512,700.00	36,186,919.00	325,781.00	99.1
210401	Бичиг хэрэг	3,780,000.00	3,779,350.00	650.00	100.0
210402	Тээвэр (шатахуун)	26,387,700.00	26,387,700.00	-	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,330,000.00	3,190,000.00	140,000.00	95.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,350,000.00	1,164,869.00	185,131.00	86.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,665,000.00	1,665,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	57,865,500.00	57,448,700.00	416,800.00	99.3
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	45,390,100.00	45,356,300.00	33,800.00	99.9
210502	Хоол, хүнс	9,100,400.00	9,100,400.00	-	100.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,375,000.00	2,992,000.00	383,000.00	88.7
2106	Эд хогшил худалдан авах	50,916,800.00	35,628,800.00	15,288,000.00	70.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,417,100.00	19,205,100.00	3,212,000.00	85.7
210602	Тавилга	4,000,000.00	2,800,000.00	1,200,000.00	70.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,000,000.00	209,200.00	1,790,800.00	10.5
210604	Урсгал засвар	22,499,700.00	13,414,500.00	9,085,200.00	59.6
2107	Томилолт, зочны зардал	1,350,000.00	661,000.00	689,000.00	49.0
210702	Дотоод албан томилолт	1,350,000.00	661,000.00	689,000.00	49.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,694,000.00	2,536,037.00	1,157,963.00	68.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,290,000.00	1,220,000.00	70,000.00	94.6
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	81,675.00	268,325.00	23.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	205,000.00	20,000.00	91.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	-	99,000.00	-
210807	Газрын төлбөр	380,000.00	5,712.00	374,288.00	1.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,350,000.00	1,023,650.00	326,350.00	75.8
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	15,034,100.00	8,203,483.00	6,830,617.00	54.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,034,100.00	8,203,483.00	6,830,617.00	54.6
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	9,960,159.91	(9,960,159.91)	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,960,159.91	(9,960,159.91)	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,960,159.91	(9,960,159.91)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,056,793,900.00	909,550,128.03	147,243,771.97	86.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,216,100.00	75,216,100.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	75,216,100.00	75,216,100.00	-	100.0

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	830,410,700.00	834,249,028.03	(3,838,328.03)	100.5
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	830,410,700.00	834,249,028.03	(3,838,328.03)	100.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	85,000.00	(85,000.00)	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	50,000.00	(50,000.00)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00	(35,000.00)	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00		20,000,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	131,167,100.00		131,167,100.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	131,167,102.50	(131,167,102.50)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	38,354,607.77	(38,354,607.77)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	31.00	31.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,867.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,464.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 22,888.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 514.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 23,402.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 15,286.3 мянган төгрөгөөс их байгаа тул **Өөрчлөлттэй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Зооноз өвчин судлалын төвөөс үнэ төлбөргүй хүлээн авсан 742.9 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайланд бүртгээгүй байсныг;
- Хувь хүний орлогын албан татварын тайлан нь цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн зардлын дүнгээс 1,721.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан

3.1 Төлбөрийн акт

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дугаар сарын 02-ны Б/02 тушаалаар Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны эхний хагас жилд 22,888.0 мянган төгрөгийн цалинг албан хаагчдад илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “*Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.*”, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “*Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.*”, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д “*Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.*”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;*” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин, НДШ-ийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: Цалин, НДШ-ийн зардлыг нийгмийн даатгалын тайлангаас 514.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*үнэн зөв байх*”, 14 дүгээр зүйлийн 14.4 “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ*”, 18 дугаар зүйлийн 18.1 “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн*”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “*Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх*” 17.1.3 “*Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах*” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ерөнхий журнал дахь Цалин, НДШ-ийн зардлыг цалингийн хүснэгт, нийгмийн даатгалын тайлантай тулган хяналт тавих

2. Шатахууны тооцоололтой холбоотой

Илрүүлэлт: Тээвэр, шатахууны зардлын зарцуулалтыг нярвын тайлангаас хөөн шалгахад албан хэрэгцээнд ашиглаж байгаа автомашины жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөж, спидометрийн заалтыг тэмдэглээгүй байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан “*Жишиг норм батлах тухай*” журамд заасан “*Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.5-т “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг холбогдох журмын дагуу бөглөж, норм баримтлан ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэгүй төлбөргүй авсан бараа материалыг санхүүгийн тайланд тусгаагүй	1	742.9			1	742.9	1	742.9		
ХХОАТ-н тайланг буруу тайлагнасан	1	1,721.2			1	1,721.2	1	1,721.2		
Дүн	2	2,464.1			2	2,464.1	2	2,464.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин, НДШ-ийн зардлыг нийгмийн даатгалын тайлангаас зөрүүтэй тайлагнасан	1	514.9					1	514.9
Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой	1						1	
Цалингийн хэмжээг нэмэгдүүлж илүү цалин олгосон	1	22,888.0	1	22,888.0				
Дүн	3	23,402.9	1	22,888.0			2	514.9

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 49/22970439/ХДА-2024/
43/ХДА-СНТ-11123

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дугаар сарын 02-ны тушаалаар Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолоор тогтоосон цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны эхний хагас жилд 22,888,038.40 /хорин хоёр сая найман зуун наян найман мянга гучин найман төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн цалинг нэр бүхий /хавсралтаар үзүүлэв/ албан хаагчдад илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно”, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно”, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д “Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үндэслэлгүйгээр цалин нэмэгдүүлэн олгосон 22,888,038.40 /Хорин хоёр сая найман зуун наян найман мянга гучин найман төгрөг дөчин мөнгө/ төгрөгийг төлбөрийн актын хавсралтад заасан албан хаагчдаар буцаан төлүүлж,

6724020160

Хөвсгөл аймгийн Төрийн санд байрших 100170000955 /Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн дарга Х.Энхсүрэн, нягтлан бодогч Т.Бүдсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

